



ЦАГДААГИЙН АЛБАНЫ НИЙТИЙГ ХАМАРСАН АРГА ХЭМЖЭЭ, ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ҮЕИЙН ХАМГААЛАЛТ ХИЙХ ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форум нь “Цагдаагийн албаны нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үеийн хамгаалалт хийх дүрэм, журмын хэрэгжилт”-д мониторинг хийх тэтгэлгийг Мэдээллийн Орхон XXI зуун ТББ-д олгосон билээ. Тус мониторингийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан “тайван замаар жагсаал, цуглаан зохион байгуулах” эрхийн хэрэгжилтийг хангах, мөн нийтийг хамарсан бусад арга хэмжээний үеэр цагдаагийн байгууллагын үүрэг оролцоог үнэлэх, сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулахыг зорилоо.

Мониторингийн дэлгэрэнгүй тайланг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

Мониторингийн хугацаанд Дархан хотод болсон нийтийг хамарсан 15 үйл ажиллагаанд ажиглалт хийж, тус үйл ажиллагаатай холбогдуулан сумын Засаг дарга болон цагдаагийн 19 алба хаагч, 19 иргэнтэй ярилцлага хийлээ.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.16, 19 дүгээр зүйлийн 19.2, 38 дугаар зүйлийн 38.7, Цагдаагийн албаны тухай хуулийн 11, 12, 40, 41, 43, 44 дүгээр зүйл, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 1, 3, 4, 5 дугаар зүйл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 500-505 хүртэлх кодод нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үед цагдаагийн байгууллагын хүлээх чиг үүргийг тодорхойлсон байдаг.

МОНИТОРИНГИЙН ДҮНГ ТОВЧЛОН ХАРУУЛБАЛ:

- Дархан-Уул аймагт сүүлийн 3 жилд зохион байгуулсан нийтийг хамарсан арга хэмжээний бүтцийг авч үзвэл баяр ёслолын үйл ажиллагаа (30 хувь), урлагийн тоглолт, үдэшлэг, цэнгүүн, спортын уралдаан (25 хувь), тодорхой тэмдэглэлт ойд зориулсан үйл ажиллагаа (25 хувь), жагсаал, цуглаан (20 хувь) байна. Тухайлбал, 2017 онд нийтийг хамарсан 39 үйл ажиллагаа зохион байгуулагдаж, нэг үйл ажиллагаанд дунджаар 4800 хүн оролцож, дунджаар 4 цаг үргэлжилжээ. 2018 онд 51 үйл ажиллагаа

зохион байгуулагдаж нэг үйл ажиллагаанд дунджаар 6400 хүн оролцож, дунджаар 6 цаг үргэлжилж байсан бол 2019 оны эхний 10 сарын байдлаар 48 үйл ажиллагаа зохион байгуулагдаж, нэг үйл ажиллагаанд дунджаар 6200 хүн оролцож, дунджаар 5 цаг үргэлжилжээ.

- Сүүлийн 3 жилийн тоо мэдээг харвал үйл ажиллагааны тоо буураагүйн зэрэгцээ оролцогчдын тоо, үргэлжлэх хугацаа өсөх хандлагатай байна. Эдгээр үйл ажиллагаанд 2017 онд 28 цагдаагийн алба хаагч, 8 олон нийтийн цагдаа, 2018 онд 32 цагдаагийн алба хаагч, 14 олон нийтийн цагдаа, 2019 онд 29 цагдаагийн алба хаагч, 6 олон нийтийн цагдаа хэв журам сахиулж ажилласнаас үзэхэд цагдаагийн бие бүрэлдэхүүний тоо өсөөгүй харагдаж байна. Гэтэл 2018, 2019 оныг 2017 онтой харьцуулахад нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцогчдын тоо 30 гаруй хувиар өсжээ.
- Хүн хүч дутмагаас үүдэн зарим үйл ажиллагааны үеэр 3 ээлжээр, тулаа гарахад хүрдгийн зэрэгцээ төлөвлөгөөт бус үйл ажиллагаанд оролцож, уртасгасан цагаар ажилладаг ч алба хаагчдад нэмэлт цалин, урамшуулал өгдөггүй байна. Холбогдох хуулиар хоол, унааны зардал өгдөг ч мөнгөн дүн нь тун бага, үүний зэрэгцээ шатахуун, холбооны хэрэгсэл дутмаг байгаа нь хүндрэл учруулдаг ажээ.
- Цагдаагийн албаны тухай хуулийн 87.5-д заасан “Цагдаагийн албан хаагчийг... ажлын бус цагаар, шөнийн ээлжид... чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно...” гэсэн заалт бүрэн хэрэгжихгүй байна.

ЗӨВЛӨМЖ

- Нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахад мэдэгдлээ ямар субъектэд хандаж гаргах, үйл ажиллагаа болохоос хэд хоногийн өмнө өгөх ёстой талаар иргэн, байгууллагад ойлголт мэдлэг өгөх;
- Нийтийг хамарсан үйл ажиллагааны үеэр цагдаатай хамтран ажиллах талаарх хууль тогтоомжийг байгууллага, иргэдэд танилцуулж, мэдлэг ойлголт өгөх, хамтран ажиллах;
- Нийтийг хамарсан арга хэмжээний үеэр үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагчийн тоог стандартын дагуу тогтоох;
- Цагдаагийн алба хаагчдад нийтийг хамарсан арга хэмжээний үеэр үүрэг гүйцэтгэхэд шаардагдах шатахууныг хүрэлцээтэй олгох;
- Цагдаагийн алба хаагчийг энгэрийн камер, холбооны төхөөрөмж, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг илрүүлдэг багаж зэргээр бүрэн хангах;
- Нийтийг хамарсан арга хэмжээний үеэр хамгаалалтад илүү цагаар ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчдад илүү цагийн хөлсийг хуульд заасны дагуу бүрэн олгох;
- Олон нийтийн цагдаагийн цалин урамшуулал, орон тоог нэмэгдүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах, хамгаалалтад оролцуулах;
- Жагсаал, цуглаан зохион байгуулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа зохион байгуулж буй байгууллага нь цагдаагийн байгууллагад зохих зардлыг хууль тогтоомжийн дагуу олгох.